



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар

А/68

Хархорин сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2, 3 дугаар багт байрлах 5 нэгж талбарын 12000 м² газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Мэдэрийн Ууганцэцэг, Дамбийнямын Амартүвшин, Цэгмэдийн Дагиймаа, Бадамдоржийн Өлзийбаяр, Жаргалсайханы Мөнхжаргал нарт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

3.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2020 оны А/214 дүгээр захирамжийн 2 дугаарт, 2019 оны А/113 дугаар захирамж, 2022 оны А/237 дугаар захирамжийн 3 дугаарт, 2022 оны А/237 дугаар захирамжийн 58 дугаарт, 2018 оны А/253 дугаар захирамжийн 3 дугаарт байгаа газар эзэмших эрхийн Э-1017000342, Э-1017000157, Э-1017000804, Э-1017000801, Э-1017000017 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

* 401100135

сумын Засаг даргын 20...
арын 07...-ний өдрийн
ар захирмжийн хавсралт

100

100